



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/52

Сүхбаатар сум

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 30 дугаар зүйлийн 30.1.15, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 9.4, Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын салбар зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

- Аймгийн Засаг даргын Нийгмийн асуудал хариуцсан орлогч дарга

Нарийн бичгийн дарга:

- Аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Боловсрол, соёл урлагийн газрын дарга
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга
- Аймгийн Цагдаагийн газрын дарга
- Мэргэжлийн хяналтын газрын дарга

C:\users\albanbichig2021\zahiramjA4.docx

470900083

- Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын дарга
- Эрүүл мэндийн газрын дарга
- Авто тээврийн үндэсний төвийн Сэлэнгэ аймаг дахь авто тээврийн газрын дарга
- Сэлэнгэ аймаг дахь Улаан загалмайн хорооны дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн Хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн тогтоол, түүний хавсралтуудад заасан үйл ажиллагааг орон нутагтаа хэрэгжүүлэн, тайланг хагас, бүтэн жилээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын албанд хүргүүлж ажиллахыг зөвлөлийн дарга /Ц.Рэгзэдмаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ